



**ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН ТЭЭВРИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025.07.23

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 70.1%-тай байна.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс (хувиар)							Хэрэгжилтийн дундаж хувь
	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
56	24	6	6	4	11	-	5	76.3

2.2. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт дараах байдалтай байна.

Арга	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин	Хэрэгжилтийн
------	----------------------------------	--------------

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ**

ХЭМЖЭЭНИЙ ТОО	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	хувь
7	1	-	2	4	42.7

2.3. МУ-ын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт дараах байдалтай байна.

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
6	3	-	-	3	64.5

2.4. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс (хувиар)							Хэрэгжилтийн хувь
	100	90	70	50	30	0	Хугацаа болоогүй	
3	1	-	1	-	1	-	-	66.7

2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл:

Нийт заалт	Үүнээс (хувиар)				Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
79	56	15	8	-	78.9

2.6. Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
48	36	12	-	-	75.0

2.7. ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс	Биелэлтийн
------------	--------	------------



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	хувь
30	26	4	-	-	86.7

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

ТЗДТБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээний зорилтот түвшнийг улирал бүрээр төлөвлөөгүй байна. /1.6, 3.2-3.4, 4.3, 6.1, 6.2, 6.6, 7.1-7.3, 8.2, 8.4/

Зам, тээврийн яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус газрын хариуцан хэрэгжүүлэх 20 арга хэмжээ тусч батлагджээ. Ингэхдээ дээрх 20 арга хэмжээнээс 1 арга хэмжээг ТЗДТБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгалгүй орхигдуулсан байна. /ЗТЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 7.3/

Хэрэгжилтийн байдал:

1) Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар 2025 онд нийт 56 арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөснөөс эхний хагас жилд 100 хувийн хэрэгжилттэй 24 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, 50 хувийн хэрэгжилттэй 4, 30 хувийн хэрэгжилттэй 11, хугацаа болоогүй 5 арга хэмжээ байгаа бөгөөд хэрэгжилт дунджаар **76.3** хувьтай байна.

2) “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, “Монголиан транс лайн” ХХК ачаа тээврийн хэмжээг нэмэгдүүлэх, Шивээхүрэн-Сэхээ боомтыг төмөр замаар холбох, Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын төслийг эхлүүлнэ, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн 384км төмөр замын төслийг эхлүүлэх, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логиستيкийн төв төслийг эхлүүлнэ, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логиستيкийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулна, Хөшигийн хөндийд хуурай боомт байгуулах нөхцөл байдлын үнэлгээ, судалгаа хийнэ, Буйр нуурт улирлын чанартай усан замын боомт байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулна, Өгий нуурт усан замын тээврийн хяналтын пост тохижуулна, Төмөр замын тээврийн үнэ тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлэх судалгаа хийнэ, “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлнэ зэрэг ажлууд хангалтгүй хэрэгжилттэй хэвээр байна.

3) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

№	Арга хэмжээ	Арга хэмжээ ний тоо	Зорилтот түвшин	Дундаж хувь
1	Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.	7	Төмөр замаар 51,0 сая.тн /ачааны хэмжээ 41.0 сая.тн/-оос доошгүй ачаа, 2.5 сая зорчигч тээвэрлэнэ.	71.4

2	Зорилт 2. Хил дамнасан төмөр замуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.	3	Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ. Ханги-Мандал боомтыг 3Г хоорондын хэлэлцээрт нэмж тусгана.	60.0
3	Зорилт 3. Төмөр замын сүлжээг өргөтгөж, 3200 км орчим төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлнэ.	6	Төслийн 1 түншлэгчтэй гэрээ байгуулна, 3 төслийн ТЭЗҮ-д бүрэн шинжилгээ хийнэ, 2 төслийн ТЭЗҮ-ийг ШУТЗ-өөр хэлэлцүүлнэ.	65.0
4	Зорилт 4. Төмөр замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангана.	4	Төмөр замын хөдөлгөөний удирдлагын барилгын ажлыг дуусгаж, системийн тоног төхөөрөмж суурилах ажлыг эхлүүлнэ. Замын их засварыг хийж дуусгана.	75.0
5	Зорилт 5. Төрийн үйлчилгээг ил тод нээлттэй, түргэн шуурхай болгож цахимжуулж. чанар, хүртээмжийг сайжруулна.	9	Төмөр замын тээврийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, шуурхай оновчтой байдлаар зохион байгуулж цахимжуулна.	90.0
6	Зорилт 6. Далай ашиглалтын хяналтыг сайжруулж, зөрчлийн тоог бууруулна.	6	Монгол Улсын далбаатай 20-оос доошгүй хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналт шалгалт хийнэ. зөрчлийн тоог 20 хувиар бууруулна.	76.7
7	Зорилт 7. Усан замын тээврийн үйл ажиллагааг өргөжүүлж, аюулгүй байдлыг хангана.	7	Усан замын хяналтын 1 пост, 2 усан замын зогсоол байгуулна. Техникийн хяналтын үзлэгт 150 тээврийн хэрэгслийг хамруулна.	65.0
8	Зорилт 8. Төмөр зам, усан зам, далайн тээврийн салбарын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	14	Бодлогын баримт бичиг-1, дүрэм-3, журам-10, стандарт-13, аргачлал-1, конвенц төсөл 2-ыг тус тус батлуулна.	82.5

4) Дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн уналтаас үүдэн нүүрс биржээр арилжаалагдаагүй, мөн хүлээн авагч талууд нүүрс хүлээн авахаас түр хугацаанд татгалзсан нь төмөр замаар ачаа тээврийн хэмжээ нэмэгдүүлэх зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлжээ. Төмөр замын зорчигч тээврийн хүртээмж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилгоор төлөвлөсөн арга хэмжээнүүдийг шат дараатай хэрэгжүүлсний үр дүнд төлөвлөсөн түвшинд хүрсэн гэж үнэлэгдэж байна.



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

5) ТЗДТБЗГ-ын 2025 оны I улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн 6 зөвлөмжөөс дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай байна. Үүнд:

1. E-Mongolia системд төмөр замын тээврийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг туршилтаар олгох үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх талаар БТГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хариуцах чиг үүрэг, хүрэх түвшнийг тодорхойлж, хэрэгжилтийг хангах;

2. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар байгуулах болсонтой холбоотой ТЗДТБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу дахин боловсруулж батлуулах;

3. Шивээхүрэн-Сэхээ боомтыг төмөр замаар холбох төмөр замын барилгын ажлыг эхлүүлж, Чойбалсан-Бичигт-Зүүнхатавч, Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн төмөр замуудын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах;

4. “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийн суурь түвшнийг судлах ажлын хэсгийг яаралтай байгуулах;

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Шивээхүрэн-Сэхээ боомтыг төмөр замаар холбох бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар дахин албан ёсны хүсэлт БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороонд гаргаж, барилгын ажлыг яаралтай эхлүүлэх;

2. Арцсуурь-Шивээхүрэн-Нарийнсухайт чиглэлийн 1255 км төмөр замын төслийн хүрээнд Шивээхүрэн Нарийнсухайт-Шинэжинст чиглэлийн төмөр замын ТЭЗУС-д бүрэн шинжилгээ хийх ажлыг яаралтай дуусгах;

3. Улаанбаатар-Шинэ Хархорум чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулж, зорилтот түвшинд хүргэх;

4. Төмөр замын тээврийн үнэ тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлэх судалгааг хийж, төмөр замын тээврийн үнэ, тариф тооцох аргачлалыг 3 дугаар улиралд багтаан боловсруулах;

5. Дорноговь аймгийн Замын-Үүд сумын “Бүс нутгийн логистикийн төв”-ийг түшиглэн хуурай боомт байгуулах ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийн асуудал болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжин хотын Дуньзян боомтод олон улсын тээвэр, логистикийн төслийг эхлүүлэх хөрөнгө оруулалтын асуудлыг яаралтай шийдвэрлэх;

6. “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийн суурь түвшнийг судлах ажлын хэсгийг яаралтай байгуулах;

7. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан 29 хувийн хэрэгжилттэй 4 арга хэмжээний биелэлтийг зорилтот түвшинд хүргэн ажиллах



ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол хянаж ажиллах;

8. Хууль тотоомж, тогтоол шийдвэр болон Зам, тээврийн сайд, Төрийн нарийн бичгийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг улирал бүр шинэчилж, монгол хэлний зөв бичгийн дүрэмд нийцүүлэн алдаагүй ирүүлж хэвших;

9. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төмөр замын газар байгуулах болсонтой холбоотой ТЗДТБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу дахин боловсруулж батлуулах. Ингэхдээ ЗТЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 7.3-т заасан арга хэмжээг шинэчилсэн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР